

НЗЗ-НЫ БАЙРУУДАД БАЙРЛАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА НУТГИЙН  
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДААС АВСАН  
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ДҮНГИЙН ТУХАЙ

ИЛТГЭХ ХУУДАС

2019.06.10

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын үндсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаар НЗЗ-ын байруудад байрлан үйл ажиллагаа явуулж байгаа нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдаас хэрэглэгчийн үнэлгээг тогтоох зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийн хугацаанд ERP систем буюу цахим хэлбэрээр авлаа. Судалгаанд нутгийн захиргааны 31 байгууллагын 707 ажилтан, албан хаагч хамрагдаж 12 төрлийн асуултын хүрээнд санал хүсэлтээ ирүүлсэн.

1. Таны ажиллаж буй өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ хангалттай явагдаж байгаа эсэх?




График 1. Өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ

Дээрхи графикаас үзэхэд өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 71% сайн, 25% дунд, 4% хангалтгүй үнэлгээ өгсөн байна.

2. Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ хангалттай явагдаж байгаа эсэх?



График 2. Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээ

Дээрхи графикаас харахад нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 67% сайн, 29% дунд, 4% хангалтгүй үнэлгээ өгсөн байна.

3. Таны ажиллаж буй байр, давхарын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ хангалттай явагдаж байгаа эсэх?



График 3. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээ

Дээрхи графикаас харахад ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 65% сайн, 28% дунд, 7% хангалтгүй үнэлгээ өгсөн байна.

4. Зоогийн газрын хоолны нэр төрөл, амт чанар таны сэтгэлд нийцэж байгаа эсэх?



График 4. Зоог, цайны газруудын хоолны нэр төрөл, амт чанар

Графикаас харахад зоог, цайны газруудын хоолны нэр төрөл, амт чаналт судалгаанд оролцогчдын 43% сайн, 42% дунд, 15% хангалтгүй үнэлгээ өгсөн байна.

5. Зоогийн газрын үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг эсэх?



График 5. Зоогийн газруудын үйлчилгээний ажилтны харилцаа

Дээрхи графикаас харахад зоогийн газруудын үйлчилгээний ажилтны харилцаанд судалгаанд оролцогчдын 62% сайн, 28% дунд, 10% хангалтгүй үнэлгээ өгсөн байна.

6. Та зоогийн газарт тав тухтай, цэвэр орчинд үйлчилгээ авч чадаж байгаа эсэх?




График 6. Зоог, цайны газруудын орчин, нөхцөл

Дээрхи графикаас харахад зоог, цайны газруудын орчин, нөхцөлд судалгаанд оролцогчдын 70% буюу 201 хүн сайн, 26% буюу 76 хүн дунд, 4% буюу 9 хүн хангалтгүй үнэлгээ тус тус өгсөн байна.

7. Таны ажиллаж буй байр, давхрын цахилгаан, ус, ариун цэврийн өрөөний хэвийн, найдвартай ажиллаж байгаа эсэх?




График 7. Цахилгаан, ус, ариун цэврийн өрөөний хэвийн ажиллагаа

Дээрхи графикаас харахад цахилгаан, ус, ариун цэврийн өрөөний хэвийн ажиллагаанд судалгаанд оролцогчдын 58% буюу 351 хүн сайн, 33% буюу 196 хүн дунд, 9% буюу 53 хүн хангалтгүй үнэлгээ тус тус өгсөн байна.

8. Цахилгаан, сантехник, мужаан, холбооны дуудлагын үйлчилгээ танд түргэн шуурхай хүрдэг эсэх?




График 8. Цахилгаан, сантехник, мужаан, холбооны дуудлагын үйлчилгээ

Дээрхи графикаас харахад цахилгаан, сантехник, мужаан, холбооны дуудлагын үйлчилгээд судалгаанд оролцогчдын 65% буюу 385 хүн сайн, 30% буюу 179 хүн дунд, 5% буюу 28 хүн хангалтгүй үнэлгээ тус тус өгсөн байна.

9. Хурлын заалны тоног төхөөрөмж шаардлага хангаж байна уу?




График 9. Хурлын заалны тоног төхөөрөмж

Дээрхи графикаас харахад хурлын заалны тоног төхөөрөмжид судалгаанд оролцогчдын 66% буюу 205 хүн сайн, 29% буюу 89 хүн дунд, 5% буюу 12 хүн хангалтгүй үнэлгээ тус тус өгсөн байна.

10. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ чанартай хүрч чадаж байгаа эсэх?




График 10. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ

Дээрхи графикаас харахад эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 61% буюу 55 хүн сайн, 22% буюу 20 хүн дунд, 17% буюу 14 хүн хангалтгүй үнэлгээ тус тус өгсөн байна.

11. Их эмч, сувилагчийн харилцаа, үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг эсэх?



График 11. Их эмч, сувилагчийн харилцаа, үйлчилгээ

Дээрхи графикаас харахад их эмч, сувилагчийн харилцаа, үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 74% буюу 65 хүн сайн, 17% буюу 15 хүн дунд, 9% буюу 7 хүн хангалтгүй үнэлгээ тус тус өгсөн байна.

12. Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаатай холбоотой гаргасан санал, хүсэлт:

Ажилтан, албан хаагчид олон төрлийн санал хүсэлт ирүүлсэн бөгөөн ихэвчлэн санал хүсэлтгүй, ННҮГ-ын үйл ажиллагаа хангалттай сайн гэсэн талархал ирүүлж байсан боловч зоог, цайны газрын хоолны ам чанарыг сайжруулах, ариун цэврийн өрөөний цэвэрлээнд анхаарах зэрэг нийтлэг санал хүсэлтийг нээлттэй асуултанд ирүүлсэн. Ирүүлсэн зарим санал хүсэлтийг байр тус бүрээр нь нэгтгэн гаргаж үзүүлбэл:

### НЗЗ-ны 1-р байр

- Өглөөний цай нэвтрүүлэх
- Тамгын цайны газар гадны хүмүүст үйлчлэхгүй байх, сандал ширээ олдохгүй, халбага сэрээ, хүрэлцээгүй болдог

- Сард нэг удаа витаминжуулалт , дархлаа дэмжих, зөв хооллолт, цагаан хоол гэх мэт өдөрлөгүүдийг хэлтэс албадуудтай хамтран зохион байгуулж алба хаагчдад мэдээлэл өгөх, мөн үдээс өмнө хөнгөн зууш цагаан идээ гэх мэт буфет ажиллуулбал сайн байна
- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд хоолны газар, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг болох хэрэгтэй байна.
- Хаалганы хаягийг хэлүүлэлтгүй өөрчилж өгч байх, хэлсэн боловч одоо болтол засч өгөөгүй байна.
- Хангарди ордны 14 давхрын хурлын танхимын захиалга, үйлчилгээ, харилцаа, хамтын ажиллагаа эрс сайжирсанд талархаж байна. Ялангуяа үйлчилгээ, цэвэрлэгээ, анхаарал их сайн байгаа, цаашид энэ эерэг хандлагаа бүх үйлчилгээнд хадгалахад анхаарах.
- Хэвлэл мэдээллийн төвийн бие засах өрөөний хоолой бөглөрөх, үнэр гарах асуудлыг цаг тухайд нь шуурхай шийдэх. Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн ажилтнуудын сууж буй өрөөний гэрэлтүүлгийг сайжруулах.

### **НЗЗ-ны 2-р байр**

- Хоолны газарт гадны хүмүүс орж үйлчлүүлж дараалал үүсгэж байна. Хоолны хүрэлцээ муу
- Өглөөний цай хүрэлцээ муу
- Аяга тавгийг уураар угаах тоног төхөөрөмжтэй болох хэрэгтэй хүмүүсийн ходоодны өвчлөл дутуу угаагдсан аяга тавгнаас шууд хамааралтай байна.
- Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээнд анхаарах
- 12 давхарын 00 өрөөнөөс бохир үнэртэж байгааг янзалж өгнө үү.
- 7 давхарын эрэгтэй нойлын гар хатаагчийг шинээр солиж өгнө үү.
- 4 давхрын эмэгтэй ариун цэврийн өрөөний хаалга нь хаагдахгүй хаалга үүдний цоож эвдэрхий орох төдий л хувцас урна. Муу цэвэрлэгээтэй үнэр нь коридорт нэвт үнэртдэг, цэвэрлэгээг сайжруулах хэрэгтэй байна.
- Цахилгаан, холбоо дуудлага өгөхөөр ирдэг боловч асуудлыг шийдвэрлэдэггүй, хэрэгцээтэй зүйлээ ав гээд явдаг. Ажил ихтэй хүмүүс барилгын материалын дэлгүүр ороод явах нь хүндрэлтэй байна. Материалын хөлсийг нь өгөөд шууд үйлчилгээгээ авахаар зохион байгуулж ажиллах.
- Шаланд бэхэлсэн цахилгааны залгуур масстай учраас интернэт сүлжээ байнга тасарч, хэвийн ажиллахад бэрхшээлтэй байна.
- Хурлын өрөө захиалах системтэй болох шаардлагатай байна.

### **НЗЗ-ны 3-р байр**

- Үйлчлэгчдийн ажлын хэрэглэл, ахуй хангамжийг сайжруулах, ажлын цагийг зөв зохицуулах шаардлагатай байн
- Цонхны шил, гадна дотор хэсэгт Улиралд 1 удаа цэвэрлэгээ хийлгэмээр байна.
- НМХГ-ын 202 тоот өрөөний цахилгааны газардуулга хэвийн эсэхийг шалгуулах

- Байрны цэвэр бохир усны болон цахилгааны шугам сүлжээний эдэлгээ өндөр, бохир ихээр үнэртдэг, ажилчид шүүлтүүргүй шууд крантны ус ууж байна.
- Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, гадна хаалганы нугас, шаардлагатай зүйлсийг хурдан шуурхай шийдвэрлэж байх.

### **НЗЗ-ны 4-р байр**

- Үйлчлэгчдийн ажлын хэрэглэл, ахуйн хангамжийг сайжруулах, ажлын цагийг зөв зохицуулах шаардлагатай.
- Цонхны цэвэрлэгээ, агааржуулалт, сүлжээний утасны холболтыг цэгцлэх.
- Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ хангалтын тал сул, хог дутуу цэвэрлэдэг, эргэх холбоо шаардлага тутмаг.
- Үйлчлэгч ажилчдыг орчин үеийн техник хэрэгсэлээр хангах.
- Хогын сав ихээр тавих, цаг тухай бүр хогоо ачуулж байх.
- Үйлчлэгч нарт тавьж өгч буй материалыг хангалттай өгөх. Заримдаа өөрсдийн мөнгөөрөө саван вок худалдаж авч байгаа харагддаг.
- 1 давхарт ажилладаг бөгөөд танай зүгээс энэ байрны 1 давхарын тасалгааны температур, бохирын шугамын үнэр маш их үнэртдэгийг яагаад шийдэж өгөхгүй олон хүний эрхийг зөрчиж байгаагаа мэддэггүй, дорвитой арга хэмжээ авдаггүй. Олон жил ийм хүнд нөхцөлд олон цагаар сууж байгаа хүмүүс байна. Нарны тусгал үзэхгүй.
- Байрны 1 давхар маш хүйтэн байдаг. Энэ давхартаа хэвийн байх ажиллах нөхцлийг хангаж өгнө үү. Мөн 00-ийн асуудал маш хүнд энэ давхарт 00 үнэртдэг эсвэл хүйтэн байдаг. Хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлж өгнө үү. Мөн дусаал гоожих гэх мэт асуудал их байгаа
- НЗЗ IV байрны 1 давхарын бохирын үнэрийг шийдвэрлэх, мөн дээд давхаруудын цонхны дулаалгын ажлыг одооноос эхлэн засварлах шаардлагатай байна.
- Нийслэлийн Засаг захиргааны 4-р байрны 6 давхарын ариун цэврийн ерөөнд нэр бүхий газрын ажилчид байнга тамхи татдаг. Ажлын 5 өдөр, өдөрт 8 цаг тамхины утаанд хордож эрүүл мэндээрээ хохирч байна. Энэхүү асуудлаар холбогдох албан тушаалтнуудад удаа дараалан гомдол мэдүүлсэн боловч үр дүнд хүрээгүй. Эрүүл ажлын орчинд ажиллах боломжийг олгож өгөхийг хүсье.
- 7 давхарын 00-д санаа тавиад өгөөч.
- Өрөө тасалгааны агаар солилцоог сайжруулах. Сэрүүцүүлэх төхөөрөмж тавих. Зуны улиралд ажлын байранд ажиллах нөхцөл хангагддаггүй. Амралттай байгаа, өвчтэй чөлөөтэй албан хаагчийн оронд ажилладаг үйлчлэгч нар ачаалал ихтэй байдаг нь ажиглагддаг.
- Нийслэлийн төр захиргааны 4-р байранд хоолны газрын асуудлыг шийдвэрлэх.
- Нутгийн захиргааны байруудад эмчтэй болмоор байна. Шаардлагатай үед эмчгүй хэцүү байдаг.
- Харуул хамгаалалтын ажилчдын үүрэг хариуцлагыг чангатгах, хариуцлагжуулах шаардлагатай байна.

### **НЗЗ-ны 5-р байр А корпус**

- Улаанбаатар чуулгын цайны газрын кассчин Мөнхцэцэг харилцааны асуудал маш муу хүнтэй зөв зүйтэй харьцдаггүй маш соёлгүй. Тиймээс арга хэмжээ авч өгнө үү.
- Цайны газрын хоолны үнийг бууруулах.

### **НЗЗ-ны 5-р байр Б, В корпус**

- Ариун цэврийн өрөөнүүдэд оо-ын цаас, гар угаах шингэн саван, мөн гар арчдаг цаастай байлгах.
- Халуун устай болох
- Өвөл маш хүйтэн тул үүнийг шийдвэрлэх.
- НЗЗ-ны 5-р байрны 2 давхрын ариун цэврийн өрөө хэрэгцээний шаардлага хангахгүй байна.
- Манай газар нь Нийслэлийн Засаг захиргааны V байранд байрладаг. Ажиллах хэвийн нөхцлийн шаардлага хангадаггүй. Дээврээс бороо, цас орох бүрт дусаал ихээр гоождог, дулаан алдагдал ихтэй, жилийн 4-н улирал тенг асаалттай байдаг нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг, ариун цэврийн өрөө эр, эм нэг дор байрладаг, халуун ус ихэвчлэн байдаггүй гэх мэт дутагдал байна.

### **Дүгнэлт:**

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын үндсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаар цахим хэлбэрээр авсан 12 төрлийн асуулттай дээрхи судалгаанд нутгийн захиргааны 31 байгууллагын 707 ажилтан, албан хаагч хамрагдаж санал хүсэлтээ илэрхийлж байсан бөгөөд судалгаанд оролцогчдын дийлэнхи хувь нь байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

- Өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 71% сайн, 25% дунд, 4% хангалтгүй,
- Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд судалгаанд оролцогчдоос 67% сайн, 29% дунд, 4% хангалтгүй,
- Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээнд судалгаанд оролцогчдоос 65% сайн, 28% дунд, 7% хангалтгүй,
- Зоог, цайны газруудын хоолны нэр төрөл, амт чаналт судалгаанд оролцогчдын 43% сайн, 42% дунд, 15% хангалтгүй,
- Зоогийн газруудын үйлчилгээний ажилтны харилцаанд судалгаанд оролцогчдоос 62% сайн, 28% дунд, 10% хангалтгүй,
- Зоог, цайны газруудын орчин, нөхцөлд судалгаанд оролцогчдоос 70% буюу 201 хүн сайн, 26% буюу 76 хүн дунд, 4% буюу 9 хүн хангалтгүй,
- Цахилгаан, ус, ариун цэврийн өрөөний хэвийн ажиллагаанд судалгаанд оролцогчдын 58% буюу 351 хүн сайн, 33% буюу 196 хүн дунд, 9% буюу 53 хүн хангалтгүй,



- Цахилгаан, сантехник, мужаан, холбооны дуудлагын үйлчилгээд судалгаанд оролцогчдын 65% буюу 385 хүн сайн, 30% буюу 179 хүн дунд, 5% буюу 28 хүн хангалтгүй,
- Хурлын заалны тоног төхөөрөмжид судалгаанд оролцогчдын 66% буюу 205 хүн сайн, 29% буюу 89 хүн дунд, 5% буюу 12 хүн хангалтгүй,
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 61% буюу 55 хүн сайн, 22% буюу 20 хүн дунд, 17% буюу 14 хүн хангалтгүй,
- Их эмч, сувилагчийн харилцаа, үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 74% буюу 65 хүн сайн, 17% буюу 15 хүн дунд, 9% буюу 7 хүн хангалтгүй үнэлгээ тус тус өгсөн.

Зарим анхаарвал зохих нийтлэг санал хүсэлтийг түүвэрлэн үзвэл байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээ, зоог, цайны газрын хоолны амт, чанар, хүрэлцээнд анхаарах шаардлагтай байгаа талаар судалгаанд оролцогчид илэрхийлж байлаа.

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ